

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04 дүгээр сарын 06

№05

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар (Microsoft teams) 15:00 цагаас 88.2 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, Р.Мядагмаа, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Г.Ариунтөгс нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:


1. ШУТИС дахь философийн боловсрол (БуХС)
 - ХУС-ын ахлах багш Э.Энхцолмон
2. “Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи” бакалаврын сургалтын хөтөлбөр (МехТС)
 - МҮС-ын дэд профессор О.Галаа, ахлах багш Л.Тэлмэнбаяр
3. МехТС-ийн “Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи” бакалаврын сургалтын хөтөлбөрөөр БНСУ-ын Кёнжугийн үндэсний их сургуультай 3+1 хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)
 - МҮС-ын дэд профессор О.Галаа, ахлах багш Л.Тэлмэнбаяр
4. Бусад асуудал
 - БАС-ийн “Усны нөөц усжуулалт” бакалаврын хөтөлбөр шинээр нээх тухай
 - БАС-ийн дэд профессор Б.Уранзаяа

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	ШУТИС дахь философийн боловсрол (БухС)	<p><i>ХЕХ-ны гишүүдийн санал:</i></p> <p>Зөөлөн ур чадвар олгох, бүтээлч, эргэцүүлэлт сэтгэлгээг хөгжүүлэх хичээл гэдгээр бүх түвшний сургалтын хөтөлбөрт тусгах;</p> <p>Бакалаврын түвшинд сэтгэлгээнд чиглэсэн нэршлээр салбар, тэнхим нь өөрийн хариуцан хэрэгжүүлж буй хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, сургалтын төлөвлөгөөний хичээл хувь харьцаанаас хамаарч заавал судлах, сонгон судлах хэлбэрийг сонгох;</p> <p>Магистрын түвшинд мэргэшүүлэх хичээлийг илүү судлах шаардлагатай тул сонгон байх;</p> <p><i>АТХА-ны санал:</i></p> <p>Ахисан түвшний хөтөлбөрт эргэцүүлэлт сэтгэлгээний хичээлийг тусгах;</p> <p>АХТА-д дундын (бакалавр, магистр, докторын түвшин) хичээлийн саналыг бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн. Тэдгээрийг нэгтгэж, санал боловсруулан ХЕХ-д танилцуулсаны дараа философийн хичээлийг сургалтын хөтөлбөрт заавал, сонгон аль хэлбэрээр тусгахыг шийдэх;</p>	<p>Бакалавр, магистр, докторын түвшинд философийн хичээлийг сэтгэлгээ талаас суралцагчийг хөгжүүлэх хичээл байх нь зүйтэй гэдгийг дэмжив.</p> <p>Бакалаврын түвшинд сэтгэлгээнд чиглэсэн нэршлийг томъёолох, салбар, тэнхим нь өөрийн хариуцан хэрэгжүүлж буй хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, сургалтын төлөвлөгөөний хичээл хувь харьцаанаас хамаарч заавал судлах, сонгон судлах хэлбэрийг сонгох;</p> <p>Ахисан түвшний хөтөлбөрт хэрхэн тусгахыг АТХА-аас гарах дундын хичээлийн хөтөлбөрийн санал, сургалтын хөтөлбөрийн журам батлагдахаар шийдвэрлэх;</p>
2.	"Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи" бакалаврын сургалтын хөтөлбөр (МехТС)	<p>Салбар дундын хөтөлбөр буюу 0788 чиглэл байгаа боловч ямар салбар дунд гэдгийг тодорхойлж, түүнтэй уялдуулан хичээлийн хувь харьцааг гаргах;</p> <p>Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хичээлийн хичээлийн суралцахуйн үр дүнтэйгээ уялдуулан тодорхойлох;</p> <p>Бусад ХДХ-ны санал хэрхэн тусгасан тухай мэдээллийн тодруулах;</p> <p>Хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээний судалгааг тодорхой</p>	<p>Монгол Улсын соёлын биет өвийг хадгалах, хамгаалах мэргэжилтний зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд анх удаа энэ чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, БНСУ-ийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх, ажил эхэлсэн зэргийг харгалзан хөтөлбөрийг дахин сайжруулж, шинэ шалгуур, шаардлагад нийцүүлэн боловсруулж, ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (93%) дэмжлээ.</p>

		<p>болгох (ажлын байрны судалгаа, төгсөгчийн ур чадвар г.м) ;</p> <p>Хичээлийн хөтөлбөрийг ШУТИС-ийн хөтөлбөр гэдгээр харж гадаад багш заахаар тодорхойлсоныг засах;</p> <p>Хөтөлбөрт археологийн инженер геологи, археологийн геофизик чиглэлийн хичээл тусгах;</p> <p>Хичээлийн хөтөлбөрийг ямар салбар чиглэлд хамаарахыг тодорхойлж, харьяалах бүрэлдэхүүн сургуулийн кодоор кодлох;</p> <p>Хөтөлбөрийн элсэлт хангалтгүй байгаад анхаарах;</p>	
3.	<p>МехТС-ийн "Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи" бакалаврын сургалтын хөтөлбөрөөр БНСУ-ын Кёнжугийн үндэсний их сургуультай 3+1 хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)</p>	<p>Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй, ХДХ-ны мэдээлэл, баримт дутуу;</p> <p>Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх ШУТИС-ийн бодлого чиглэлийг баримтлах;</p> <p>Хамтарсан хөтөлбөр дээр хэлний шаардлага чухал тул гадаад хэлний сургуультай хамтран ажиллах;</p> <p>Солонгос талд судлах хичээлийн шаардлагыг тодорхой болгох;</p>	<p>Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй баримт дутуу байгаа, дахин сайжруулалт хийх шаардлагатай, үндсэн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа зэргийг харгалзан дахин МехТС болон бусад холбогдох ХДХ-оор хэлэлцүүлсэн тэмдэглэлийг үндэслэн дахин хэлэлцүүлэхээр буцаалаа.</p>
4.	<p>Бусад:</p> <p>БАС-ийн "Усны нөөц усжуулалт" бакалаврын хөтөлбөр шинээр нээх санал</p>	<p>Хөтөлбөрийн боловсруулалт дутуу (хичээлийн хөтөлбөр);</p> <p>БуХС, ГХС, ГУУС, ХШУС-ийн хөтөлбөрийн дэд хороонд танилцуулж санал авч тусгах;</p> <p>БАС-ийн ХДХ хөтөлбөрийн боловсруулалт дээр дахин ажиллах шаардлагатай;</p>	<p>Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй, хичээлийн хөтөлбөр дутуу, бусад салбар чиглэлд хэлэлцүүлэх шаардлагатай тул шинэчилсэн хөтөлбөр боловсруулах шалгуур, шаардлагын дагуу сайжруулан, БАС болон бусад холбогдох ХДХ-оор хэлэлцүүлж, саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр буцаалаа.</p>

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Г.Ариунтөгс
/ХЕХ-ны гишүүн/